**ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН**
**ТУШААЛ**

2022 оны 12 сарын 30 өдөр Дугаар А/356 Улаанбаатар хот

**Хөрөнгө бүртгэлд тусгах,**
**хуваарилах тухай**

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсэг, Гаалийн тухай хуулийн $271^1$ дүгээр зүйлийн $271^1$.1.1, $271^1$.1.12 дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолын 4.1.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж байгаа Гаалийн шинэчлэл, боомтын сэргэлтийн бодлогын хүрээнд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Шивээхүрэн хилийн боомтод суурилуулсан ачаа тээврийн хэрэгслийн хурдасгуурт рентген тоног төхөөрөмжийг Гаалийн ерөнхий газрын Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн балансад 1 дүгээр хавсралтаар, Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн балансаас Гаалийн ерөнхий газрын харьяа Шивээхүрэн дэх гаалийн газрын балансад хуваарилж бүртгэлд тусгах хөрөнгийн жагсаалтыг 2 дугаар хавсралтаар тус тус батлаcугай.

2. Хөрөнгийг хүлээн авч, нягтлан бодох бүртгэлд тусган гаалийн хяналт шалгалтад ашиглахыг Шивээхүрэн дэх гаалийн газар /М.Өнөрбуян/-т даалгасугай.

3. Уг рентген тоног төхөөрөмжийг гаалийн хяналт шалгалтын зорилгоор ашиглахад хяналт тавьж ажиллахыг Гаалийн хяналт шалгалтын газар /Б.Даваасүрэн/-т үүрэг болгосугай.

4.Энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэс /Д.Долгорсүрэн/-т үүрэг болгосугай.

ДАРГА Р.ОТГОНЖАРГАЛ

1439501 3883

Гаалийн ерөнхий газрын даргын
2022 оны 12 дугаар сарын 30-ны
өдрийн А/336 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт

## Гаалийн ерөнхий газрын Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн балансад бүртгэх тоног төхөөрөмжийн жагсаалт

/төгрөгөөр/

| № | Бараа материал | Марк | Огноо | Тоо хэмжээ | Нэг бүрийн үнэ | Татвар | Нийт үнэ | Хуримтлагдсан элэгдэл | Үлдэгдэл өртөг |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Ачаа тээврийн хэрэгсэлийн хурдасгуурт рентген тоног төхөөрөмж | ISB-A 005 | 12/30/2022 | 1 | 5,206,500,000.00 | 476,510,334.30 | 5,683,010,334.30 | - | 5,683,010,334.30 |
| **НИЙТ** | | | | **1** | **5,206,500,000.00** | **476,510,334.30** | **5,683,010,334.30** | **-** | **5,683,010,334.30** |

Гаалийн ерөнхий газрын даргын
2022 оны 12 дугаар сарын 30-ны
өдрийн А/356 дугаар тушаалын 2 дугаар хавсралт

**Гаалийн ерөнхий газрын Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн балансаас Гаалийн ерөнхий газрын харьяа Шивээхүрэн дэх гаалийн газрын балансад хуваарлах тоног төхөөрөмжийн жагсаалт**

/төгрөгөөр/

| № | Эзэмшиж буй газар, хороо | Бараа материал | Марк | Огноо | Тоо хэмжээ | Нэг бүрийн үнэ | Татвар | Нийт үнэ | Хуримтлагдсан элэгдэл | Үлдэгдэл өртөг |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэс | Ачаа тээврийн хэрэгслийн хурдасгуурт рентген тоног төхөөрөмж | ISB-A 005 | 12/30/2022 | 1 | 5,206,500,000.00 | 476,510,334.30 | 5,683,010,334.30 | - | 5,683,010,334.30 |
| **НИЙТ** | | | | | **1** | **5,206,500,000.00** | **476,510,334.30** | **5,683,010,334.30** | **-** | **5,683,010,334.30** |